**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

*Хянасан:* ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА........................................./Д.ДЭЛГЭРСАЙХАН/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*Тэмдэг* ....................

*(огноо)*

*Тайлан бичсэн:* ***Төсвийн Шууд захирагч***

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА.................................................../Ц.МӨНХЖАРГАЛ/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*Тэмдэг* ....................

*(огноо)*

## БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратегитөлөвлөгөөболон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГДҮГЭЭР ЗОРИЛГО:БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | | | | | |
| **Зорилт 1**.Улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулна.,“ Аймгийн 2021 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөө”-ний 4.108. | | | | | | | |
| 1.1.1 | Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээ, мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хариуцах, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах | - | Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанаас шалтгаалсан доголдлыг арилгасан тоо; | 2020 онд хэлтсийн хэмжээнд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжид давхардсан тоогоор нийт 18 засвар үйлчилгээг хийсэн. | Улсын бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан, техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа хангагдсан байна. | -Тайлант хугацаанд хэлтсийн хэмжээнд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжид нийт 13 удаагийн засвар үйлчилгээг хийсэн.<br>-“Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарын ашиглаж буй скайнерын судалгаа”-г ирүүлэх тухай ЭХЭУБГ-аас 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн дотоод албан бичгийн дагуу холбогдох судалгааг гаргаж заасан хугацаанд нь edkhurungu@burtgelgov.mn хаягаар хүргүүлсэн. Үүний үр дүнд УБЕГ-аас Canon DR-M260 маркийн 1 үйлдэлт скайнер 2, хурдны Epson ds-530 маркын 1 үйлдэлт скайнер 1 ширхэг, нийт 3 скайнертай болж бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх нөхцөл бүрдсэн. 2021 оны 08-09 дүгээр саруудад КОЯКА-ийн төслийн хүрээнд 20 сумын иргэний улсын бүртгэгч нарын бүртгэлийн тоног | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төхөөрөмжийг бүрэн шинэчилж олгосныг хүлээн авч сумдаар явж сүлжээнд холбон тохиргоог хийж ашиглалтанд оруулсан. Шинэчилсэн бүртгэлийн хуучин тоног төхөөрөмжүүдийг сумдаас татан авч УБЕГ-ын санхүүд буцаан хүлээлгэн өгсөн. | |
| 1.1.2 | Хэлтсийн үйлчилгээний танхимд цахим үйлчилгээний булан бий болгох | - | Цахим үйлчилгээний булангаар үйлчлүүлсэн үйлчилгээний тоо; | Нэг цэгийн үйлчилгээ, E mongolia-аар улсын бүртгэлийн 103 лавлагаа, үйлчилгээ үзүүлсэн. | Цахим буланг үйл ажиллагаанд хэрэглэж эхэлсэн байна. | Хэлтсийн үйлчилгээний зааланд иргэд үйлчлүүлэгчдэд зориулан e-mongolia цахим үйлчилгээний апплейкшнаас үйлчилгээ авах зориулалт бүхий хэсгийг хуучин ширээ сандал, компьютер принтер байршуулж 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн ажиллуулж эхэлсэн ба 2021 оны 10 сард албан тоотоор хүсэлт илгээж 5 сая төгрөгийг шийдвэрлүүлж цахим үйлчилгээний буланг шинэчлэн тохижуулж шинэ компьютер, принтер, түүнийг байрлуулах бүхээг бүхий шүүгээ, сүлжээний утас зэргийг худалдан авч ашиглалтанд оруулав. Нийт 337 хүн үйлчилгээ авсан байна. Сумдын бүртгэгчдээс 208 иргэн үйлчилгээ тус тус авсан байна. | 100 хувь |
| 1.1.3 | Үйлчилгээний төлбөр, хураамжийг цахим машин, төлбөрийн системээр авах нөхцлийг бүрдүүлж, сурталчилан ажиллах | - | -Цахим машин, төлбөрийн системээр хийгдсэн төлбөр хураамжийн тоо;<br>-Сурталчилсан байдал; | 2020 онд И-баримт апп 400, Киоск цахим төлбөрийн машинаар 0 иргэн үйлчилгээ авсан. | Цахим хэлбэрээр төлбөр төлсөн иргэдийн тоо нэмэгдсэн байна. | Улсын бүртгэлийн үйлчилгээний хураамжийг 2017-2019 онуудад Төрийн банк болон Голомт банкны пос машинаар авч байсан боловч УБЕГ-аас ашиглаж болохгүй гэж чиглэл өгсөн дагуу зогсоосон. Харин энэ онд хатуу хөл хорио тогтоож банкууд ажиллахгүй байх | 90 хувь. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацаанд Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээнд 50 удаа киоск машинаар төлбөр төлүүлсэн, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээнд ХААН банкинд байрлах Киоск машинаар төлбөрийг 20 удаа төлүүлсэн боловч тус машины баримт дээр “Киоск машинаас хэвлэсэн энэ хүү баримт нь зөвхөн таны гүйлгээний мэдээллийг хүлээн авсан тухай бөгөөд, гүйлгээ бүрэн амжилттай хийгдсэн тохиолдолд таны банкинд бүртгэлтэй и-мэйл хаягт баталгаажуулсан баримт хүргэгдэнэ.” гэсэн нь төлбөр үнэн зөв төлөгдснийг баталгаажуулах баттай нотлох баримт болж чадахгүй байна гэж үзсэн тул үйлчилгээнд ашиглахгүй байгаа болно. E-mongolia апп-аар иргэний цахим үнэмлэх захиалсан 96, гадаад паспорт захиалсан 32 иргэн цахимаар төлбөрөө төлсөн байна. Цахимаар бүртгэлийн үйлчилгээ авч, төлбөр төлөх боломжтой болсон талаар бүртгэлийн зөвлөгөө, үйлчилгээ авах иргэн бүрт мэдээллийг өгч ажилласан төдийгүй, зар сурталчилгааны шторк мэдээллүүдийг хэлтсийн цахим хаягаар тухай бүр нь олон нийтэд түгээн ажиллаж байна. Аймгийн ЗД-аас 5 сая төгрөг шийдвэрлэсэн нь дизель мотор | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авч хүрэлцэхгүй тул Гэрэгэ-киоск байршуулах гэж байсан болобч УБЕГ-аас Сангийн яамнаас зөвшөөрөхгүй байгаа тухай мэдээлэл ирүүлсэн тул хөрөнгийг үйлчилгээний цахим буланг тохижуулахад шилжүүлсэн болно. | |
| 1.1.4. | Улсын бүртгэлийн хэлтсийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 5 сая | Байгалийн гэнэтийн гамшиг аюулаас шалтгаалан үйлчилгээ доголдож иргэдээс гомдол гараагүй байх | 2018-2020 онуудад үер усны аюулаас шалтгаалан өндөр хүчдлийн шон унаж 3-7 хоногийн цахилгааны тасалдлаас шалтгаалан төрийн үйлчилгээ тасалдсан. | Байгалийн гэнэтийн гамшиг аюулаас шалтгаалж бүртгэлийн үйлчилгээнд саатал гарахгүй хэвийн ажиллана. | Хэлтсийн даргын 2020 оны албан тоотоор санал хүргүүлж 2021 оны Үндсэн чиглэлд 5 сая төгрөг тусгуулсан. 2021 оны 01 дүгээр сарын 18-ны 1/28 тоот Хүсэлт хүргүүлэх тухай албан тоотоор хөрөнгө нэмж шийдвэрлүүлэх хүсэлтийг дахин хүргүүлсэн болович орон нутгийн төсөвт тодорхой хүндэрлүүд байгаа учраас боломжгүй байна гэсэн хариу өгсөн. Хэлтсийн даргаас дахин 10 сарын 12-ны 1/765 тоот албан хүсэлт явуулж үйлчилгээний заалны цахим булангийн иргэд үйлчүүлэгчдийн ашигладаг компьютер тоног төхөөрөмжийг шинээр авч тохижуулан ашиглалтад оруулсан болно. | 100 хувь |
| **ХОЁРДУГААР ЗОРИЛГО: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ** | | | | | | | |
| **Зорилт 2**.Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай үзүүлнэ. | | | | | | | |
| 2.2.1 | Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөх | - | -Бүртгэлийн тоо; | Өмнөх онд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 18518, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 1254, эд хөрөнгийн эрхийн улсын | Улсын бүртгэл үнэн зөв хөтлөгдөж, иргэдэд хүртээмжтэй хүрсэн байна. | • Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 12806 бүртгэл бүртгэсэн байна. Үүнд: Төрсний бүртгэл 1417, Гэрлэсний бүртгэл 348, гэрлэлт дуусгавар болсны 45, үрчилсний 28, эцэг/эх/ тогтоосны 57, овог, | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бүртгэлийн чиглэлээр 9327 бүртгэл хийгдсэн. | | эцэг/эх/-ийн нэр өөрчилсөн 55, нас барсан 366, регистрийн дугаар өөрчилсөн 6, Дахин олгосон гэрчилгээ 286, иргэний үнэмлэх 3256, Үндэсний энгийн гадаад паспорт 206, Шилжилт хөдөлгөөн 1932, лавлагаа 4804 олгосон. Тайлант хугацаанд улсын төсөвт 64,129,606 , орон нутгийн төсөвт 13,368,551 төвлөрүүлж ажилласан байна. Эд хөрөнгийн эрх улсын бүртгэлийн чиглэлээр эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн нийт 11807 мэдүүлэг хүлээн авч шийдвэрлэснээс газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэл 5683, газар өмчлөх эрхийн улсын бүртгэл 4411, газар эзэмших эрхийн улсын бүртгэл 1713 бүртгэгдсэн байна. Мөн МИК активаас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу эрх сэргээсэн тусгай тэмдэглэлийн бүртгэл 104, хууль хяналтын байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн дагуу эрх сэргээсэн, эрх түдгэлзүүлсэн бүртгэл 56 бүртгэгдсэн байна. Харин Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 841 өргөдөл хүсэлт хүлээн авч холбогдох бүртгэлийг хөтлөн баталгаажуулсан байна. | |
| 2.2.2 | Аймгийн нутаг дэвсгэрт | - | -Аймгийн нутаг | 2020 оны жилийн эцэст | Аймгийн нутаг | 2021 оны жилийн эцсийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдийн салбар төлөөлөгчийн газрыг бүртгэлжүүлж, гэрчилгээ олгох | | дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газрыг бүртгэсэн тоо;<br>-Олгосон гэрчилгээний тоо; | гадны аймаг нийслэлийн харьяа 11 салбар төлөөлөгчийн газар бүртгэж гэрчилгээ олгосон. | дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн бүртгэлтэй салбар төлөөлөгчийн газрыг урьд оны мөн үеэс 1%-иар нэмэгдүүлнэ. | байдлаар хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын бүртгэл 4 бүртгэгдсэн. | хувь |
| 2.2.3. | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх, тулгалт хийх ажлыг үе шаттайгаар хийх ажлыг үргэлжлүүлэх | | -Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд зөрүүтэй орсон, алдаатай орсон мэдээллийг засч оруулсан тоо;<br>-цахим мэдээллийн сангийн чанар 10 хувиар сайжирсан байна. | 2020 онд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэг буюу цаасан суурьт баримтыг цахим мэдээллийн сантай тулгах ажлыг жилийн туршид хийж гүцэтгэн цахим санд алдаатай, зөрүүтэй, буруу бүртгэгдсэн 204 хувийн хэрэг бүртгэлийг залруулахаар Хяналтын улсын байцаагчийн 26 удаагийн дүгнэлтийг гаргуулж, цахим системд мэдээллийг засварлах, нөхөн скайнердах ажлуудыг хийж бүртгэл үнэн зөв байх зарчмыг ханган ажиллалаа | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй эд хөрөнгө өмчлөгч иргэний регистр, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр нь иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь иргэний регистр, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэртэй зөрсөн, нэрийн бичиглэл зөрүүтэй алдааг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн тухай бүр засч оруулсан байна. | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэг буюу цаасан суурьт баримтыг цахим мэдээллийн сантай тулгах ажлыг 2021 оны 4,5 сард хийхээр төлөвлөсөн байсан боловч Засгийн газраас бизнес эрхлэгчдийг дэмжин зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх төсөл хэрэгжсэнтэй холбоотойгоор ажлын ачаалал болон бүртгэлийн үйлчилгээний тоо хэмжээ асар их нэмэгдсэнтэй холбоотойгоор тус ажлыг төлөвлөсөн хугацаанаасаа хойш 7 сараас эхлэн хийгдсэн. Тайлант хугацаанд нийт 170 хувийн хэрэг бүртгэлийг залруулахаар хяналтын улсын байцаагчийн 22 удаагийн дүгнэлтийг гаргуулж, цахим системд мэдээллийг засварлах, нотлох баримтыг нөхөн, дахин скайнердаж оруулан бүртгэл үнэн зөв байх зарчмыг ханган ажиллаж байна. Мөн эд хөрөнгийн эрхийн улсын | 90 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүртгэлийн хувийн хэргийн цаасан суурьт баримтыг цахим сантай тулган тоолох ажлын хүрээнд цахим сантайгаа зөрүүтэй, үйлчилгээний дараалал буруу орсон, дугаарлалтын алдаатай, үйлчилгээний төрөл буруу нэрлэсэн гэх мэт алдаатай, цахимжсан газрын 161, үл хөдлөх эд хөрөнгийн 457 хувийн хэргийг зөрчилийг илрүүлсэн ба Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулахаар тулган шалгах ажиллагаа хийгдэж байна. | |
| 2.2.4 | Улсын бүртгэлийн байгууллагаас мэдээлэл, лавлагаа өгөх | - | -Улсын бүртгэлтэй холбоотой олгосон мэдээлэл, лавлагаа, нотлох баримтын тоо;<br>-Эрхийн улсын түтгэлзүүлсэн бүртгэлийн тоо; | 2020 онд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд 7194, хууль хяналтын байгууллагад 895 иргэний лавлагаа, мэдээллийг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд 6, хууль хяналтын байгууллагад 66, хуулийн этгээдэд 48 лавлагаа, мэдээлэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас 179 иргэн, хуулийн этгээдэд 17 лавлагаа хуулбар, хууль хяналтын байгууллагад 549 албан бичгээр лавлагаа тус тус олгосон. | Улсын бүртгэлтэй холбоотой үнэн зөв лавлагаа, мэдээлэл, нотлох баримтыг хуульд заасан хугацаанд олгосон байна. | Тайлант хугацаанд нийт 6303 лавлагаа олгосноос иргэнд 4765, албан хэрэгцээнд 757 лавлагааг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан, мэдээлэл удирдах системд шалган, шаардлагатай тохиолдолд иргэний баримтын архиваас эх нотлох баримтыг татан авч тулгаж иргэдэд лавлагаа олгож байна.<br>Баянхонгор аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газруудад 735 удаагийн албан бичгээр хандсан 781 лавлагаа мэдээллийг хугацаанд нь гарган өгч гэмт хэрэг зөрчлийг илрүүлэх, арилгах үйл ажиллагаанд төрийн байгууллагуудын уялдаа холбоог хханган ажиллаж байна.<br>- Хуулийн этгээдийн бүртгэлийн | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | улсын бүртгэлийн архив мэдээллийн сангийн баазаас холбогдох лавлагаа, мэдээллийн үйлчилгээ нийт 64, нотлох баримтын хуулбар олгох үйлчилгээ 8-ыг үзүүлсэн байна.<br>Лавлагаа, мэдээллийн үйлчилгээг төрлөөр нь авч үзвэл;<br>1.Иргэнд-2<br>2.Хуулийн этгээдэд-37<br>3.Төрийн байгууллагад-25<br><br>- Үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой лавлагаа 77, архивын лавлагаа болох эд хөрөнгөтэй эсэх, эд хөрөнгийн түүхчилсэн лавлагаа 25, хууль хяналтын байгууллагын албан хүсэлтийн дагуу 286 нийт 388 лавлагаа олгож, эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой нотлох баримтын хуулбар 44 мэдүүлгээр 46 хуудас нотлох баримтыг олгосон байна. | |
| 2.2.5 | Санхүүгийн тайланг найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй хуулийн этгээдийг Сангийн яамны саналыг үндэслэн байгууллагын цахим хуудсаар нийтэд зарлан хуульд заасан | | -Санхүүгийн тайланг найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээх;<br>-<br>Баталгаажуулааг | 2020 оны жилийн эцсийн байдлаар 5 хуулийн этгээд татан буугдсан байна. | Улсын бүртгэлээс хасагдах хуулийн этгээдийг байгууллагын цахим хуудсаар нийтэд зарласан байна.<br><br>Хуульд заасан хугацааны дараа хуулийн этгээдийг улсын бүртгэлээс | Тайлант хугацаанд татан буугдсан бүртгэл 5 хийгдсэн байна. | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хугацаанд улсын бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулах | - | үй хуулийн этгээдийг Сангийн яамны саналыг хүлээн авах;<br>-Байгууллагын цахим хуудсаар нийтэд зарлах;<br>-Хуульд заасан хугацаанд улсын бүртгэлээс хасах; | | хасах бүртгэл хөтөлсөн байна. | | |
| 2.2.6 | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг суманд үзүүлж эхлэх бэлтгэл ажлыг хангах, судалгааг УБЕГазарт хүргүүлэх; | - | -Хүний нөөцийн судалгаа гаргаж,сумдын улсын бүртгэгч нарт цахимаар сургалт зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангах;<br>-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг суманд үзүүлж эхлэх; | Сумаас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлдэггүй. | Алслагдсан сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулсан байна. | УБЕГ-аас эрх зүйч мэргэжилтэй сумдын иргэний улсын бүртгэгчдийн судалгаа авахаар ирүүлсэн маягтын дагуу 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр l.unurtuya@burtgel.gov.mn хаяг руу хүргүүлсэн. Уг сургалтанд хамрагдах 5 бүртгэгчид Ерөнхий газраас ирүүлсэн мэдээ мэдээлэл, сургалтын линкүүдийг цаг алдалгүй түргэн шуурхай хүргэж мэдээллээр бүрэн хангаж, сургалтанд идэвхтэй хамрагдаж амжилттай дүүргэхийг үүрэг болгон ажиллаж байна.<br>Сургалтанд албан хаагчид хамрагдаж шалгалтад амжилттай дүн үзүүлсэн. | 95 хувь. |
| 2.2.7 | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн хариуцлагын даатгалын гэрээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион | - | -Гэрээний хэрэгжилтийн хувь; | “ХААН даатгал” ХХК-тай хамтарч бүртгэгч нарын хариуцлагын даатгал хийгдэж эхэлсэн. | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарыг хариуцлагын даатгалд хамруулж, гэрээний хэрэгжилт | Улсын бүртгэгчийн даатгалын гэрээг Улсын бүртгэлийн Ерөнхий газар ХААН даатгалтай байгуулсан. Улсын бүртгэгчийн хариуцлагын даатгал болон даатгалын | 100 хувь. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах | | | | бүрэн хангагдсан байна. | гэрээний талаар ХААН даатгал болон Эд хөрөнгийн бүртгэлийн газраас зохион байгуулсан онлайн сургалтанд эд хөрөнгийн улсын бүртгэгч нарыг бүрэн хамруулав. | |
| **Зорилт 3.** Улсын бүртгэл болон улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулна. | | | | | | | |
| 2.3.1 | Хяналт шалгалтын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангах | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь; | 2020 онд төлөвлөгөөт 5, гэнэтийн болон төлөвлөгөөт бус 2 хяналт шалгалт хийж, 233 дүгнэлт гаргасан. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажилласан байна. | 2021 онд төлөвлөгөөт шалгалт-5, гэнэтийн болон төлөвлөгөөт бус шалгалт-1, гүйцэтгэлийн шалгалт -1 хийгдсэн байна. Харин өргөдөл, санал, гомдлын мөрөөр хийсэн шалгалт 337 байна. 2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу говийн бүсийн Баянлиг, Баянговь, Богд, Жинст, Баацагаан, Баянцагаан, Баян-Өндөр, Хангайн бүсийн Заг, Жаргалант, Галуут, Баян-Овоо, Гурванбулаг сумдын улсын бүртгэгч нарын 2021 оны эхний хагас жилийн 350 бүртгэлд, III улиралд говийн бүсийн Баянговь, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Жинст сумдын 216 бүртгэл, хангайн бүсийн Бууцагаан, Бөмбөгөр, Хүрээмарал,Баянбулаг, Заг сумдын 322 бүртгэлд тус тус хяналт шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтаар нотцой зөрчил дутагдал илрээгүй болно. Улсын бүртгэл хөтлөхтэй холбоотой арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа. Нийт 184 дүгнэлт гаргасан. | 95 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3.2 | Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн зөрчлийг арилгах | - | -Зөрчилтэй иргэдийн тоо;<br>-Зөрчлийг арилгасан тоо; | 2020 онд мэдээлийн санд зөрчилтэй бүртгэгдсэн 1200 иргэдийн зөрчлийг УБЕГ-ын ИУБГ-т 62 албан бичиг хүргүүлж арилгуулсан. | Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн илэрсэн зөрчлийг 100% арилгасан байна. | Тайлант хугацаанд хяналтын улсын байцаагчийн 150 ш дүгнэлтээр 711 иргэний мэдээллийг улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах, иргэний цахим үнэмлэх хүчингүй болгуулах, иргэний улсын бүртгэлийн санд мэдээлэл засуулах зэрэг ажлыг бүрэн тусгуулсан байна. | 100 хувь |
| 2.3.3 | Улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах | - | Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд гарах зөрчлийг бууруулсан тоо; | 2020 онд нийт 29948 бүртгэлд хяналт шалгалт хийж, 393 зөрчил илрүүлж арилгасан. | Улсын бүртгэлийн үйлчилгээ иргэн, хуулийн этгээдэд тэгш, хүртээмжтэй, чирэгдэлгүй хүрсэн байна. | Иргэний бүртгэл -141, Эд хөрөнгийн чиглэлээр -65, Хуулийн этгээд -10, Улсын бүртгэлийн архивын /иргэний/ чиглэлээр -116, Нийт 332 зөрчил илрүүлснийг тухай бүр залруулж ажиллалаа.Зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтуудыг хийж тухайн бүр нь зөвлөмж өгч ажилласан. | 100 хувь |
| 2.3.4 | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх | - | Шалган шийдвэрлэсэн зөрчлийн тоо; | 2020 онд Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн нийт 1260 иргэн, 6 хуулийн этгээдийн зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж, торгох шийтгэл оногдуулан 32150000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. | Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн тоо буурсан байна. | Зөрчлийн тухай хуульд заасны дагуу нийт 407 иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.Үүнээс 374 иргэн, 2 хуулийн этгээдэд шийтгэл ногдуулж, улсын төсөвт 9960 **000** төгрөгийн орлого төвлөрүүлж, харин 31 иргэний өргөдлийн материалыг **татгалзаж** шийдвэрлэсэн байна. Зөрчлийн тухай хуульд заасан Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу Прокурорын байнгын хяналтан | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дор явуулж байна.<br>Өршөөл үзүүлэх тухай хууль болон Гамшгийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор өмнөх онуудаас Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл ногдуулсан тоо буурсан байна. | |
| 2.3.5 | Аймгийн хэмжээнд иргэний байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн зөрчил арилгах ажлыг зохион байгуулах | - | Арилгасан зөрчлийн тоо; | - | Иргэний оршин суугаа газрын хаягийн зөрчлийг арилгасан байна. | -Төрсний бүртгэлд эхийн мэдээлэл тусгагдаагүй шалтгааны улмаас Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд байнга оршин суугаа хаягийн бүртгэлгүй 2004, 2005 онд төрсөн 15 иргэний хаягийг тусгуулсан. Мөн иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй байсан иргэн Д.Арвинболд /вй64053015/-ын оршин суугаа хаягийг тусгуулж биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд бүртгэсэн.<br>-Шилжилт хөдөлгөөний бүртгэлээр байнга оршин суугаа газрын хаягийг буруу бүртгэсэн 1 зөрчлийг илрүүлж хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр зөрчлийг арилгасан.<br>- ИУБТХ-ийн 19.4-т заасан асуудлаар иргэнээс хүсэлт гаргаагүй болно.<br>- Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын 6 дугаар багийн төвийн нэршил нь Иргэний улсын бүртгэлийн хаягийн санд тусгагдаагүй зөвхөн 6-р баг гэж байсныг сумаас нь холбогдох нотлох баримт, хүсэлтүүдийг хавсарган | 95 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авч судлан “Эрдэнэцогт сум 6-р баг Цагаан дэнж” болгохоор хяналтын улсын байцаагчаар дүгнэлт гаргуулан Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн. Тус багт өнөөдрийн байдлаар нийт 947 иргэн бүртгэлтэй байгаа ба тус иргэдийн хаягийн зөрчил мэдээллийн санд зөвөөр тусгагдан, хаягийн зөрчил арилна. Иргэний улсын бүртгэлийн газраас 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 4/7845 тоот “Мэдээлэл ирүүлэх тухай” албан бичгийн дагуу Баянхонгор аймгийн хэмжээнд бичвэрийн зөрүүтэй байгаа хаяг 49, Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй боловч иргэн бүртгэлгүй хасах хаяг 9 сумын хэмжээнд Орон нутгийн хэмжээнд хаягжуулалтын тухай хуулийн дагуу хаяг өөрчилсөн боловч иргэний цахим мэдээллийн санд тусгаагүй байгаа хаяг, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх хаяг нь Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангийн хаягтай зөрсөн судалгааг тус тус дэлгэрэнгүйгээр гаргаж хүргүүлсэн. | |
| **Зорилт 4.** Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хөмрөг бүрдүүлж, баяжилт хийж, түүний хадгалалт хамгаалалтыг сайжруулна. | | | | | | | |
| 2.4.1 | Иргэний, Хуулийн | | Архивын сан | 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн | Архивын сан хөмрөгийг бүртгэлийн | 2021 оны 11 сарын байдлаар Иргэний улсын бүртгэл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | этгээдийн болон Эд хөрөнгийн архивын сан хөмрөгийн баяжилтыг тухай бүр хийх | | хөмрөгийн бүрдүүлэлт баяжилтыг сар бүр хийсэн бүртгэлийн тоогоор баяжилт хийгдсэн эсэх | байдлаар архивт ИУБ маягт нийт 11337 ш хүлээн авч байршуулаад байна. Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр тайлант хугацаанд шинээр үүссэн 8643 хувийн хэрэг хүлээн авсан.<br>Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр шинээр байгуулагдсан 148 аж ахуй нэгж, нэмэлт өөрчлөлти йн 262 аж ахуйн нэгжийн хувийн хэргийг хүлээн авч байршуулсан. | эх нотлох баримт бичгээр бүрдүүлж, баяжилтыг тухай бүр хийж гүйцэтгэнэ. Мөн архивын хадгалалт хамгаалалт сайжирсан байна. | хөтөлсөн нийт **10573** ширхэг ИУБ маягтыг “Архивт маягт хүлээлцэх бүртгэл” болон нэрийн жагсаалтын хамт хүлээн авч цагаан толгойн үсгийн дараалаар галиглан, архивт хүлээн авч хувийн хэргийн нэгдсэн санд нэг бүрчлэн байршуулж хувийн хэргийн баяжилтыг хийж ажиллалаа. Иргэний улсын бүртгэлийн ИУБ маягтуудыг хуулийн хугацаанд нь архивт бүрэн байршуулж дууссан байна .<br>Эд хөрөнгийн чиглэлээр нийт 11003 ширхэг бүртгэл, маягтыг хүлээн авч код, дугаараар байршуулан хадгаламжийн нэгжийн баяжилт, хаягжуулалтыг хийсэн байна.<br>Хуулийн этгээдийн бүртгэлийн 150 ширхэг шинэ хувийн хэрэг, “Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн баримт бичгийг архивт шилжүүлсэн жагсаалт”-аар 202 ширхэг нотлох баримт материал хүлээн авч хувийн хэрэг тус бүрт нэгтгэн байршуулж хувийн хэргийн баяжилт, хаягжуулалт хийж ажиллалаа. | хувь |
| 2.4.2 | Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн баримтын архивын тооллого хийж, баримтыг данс бүртгэлжүүлэх | - | -Тоолсон иргэний баримтын тоо;<br>-Тоолсон хуулийн этгээдийн хувийн хэргийн тоо;<br>-Тоолсон эд | 2020 оны жилийн эцэст иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн баримтын архивт 200936 хувийн хэрэг хадгалагдаж байна. | Хэлтсийн бүртгэлийн төрөлжсөн архивын баримтыг 100% тоолсон байна. | “Тооллого явуулах тухай” хэлтсийн даргын 2021-09-20 өдрийн А/14 дугаар тушаалын тооллогот албан хаагчид бүрэн хамрагдан ажиллаж дууссан. Иргэний улсын бүртгэлийн архивын тооллого нь хувийн хэргийн нэгдсэн сангийн А-Я | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөрөнгийн хувийн тоо; | | | үсэг дуустал нийт **109707ш** хувийн хэргийг Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шалгаж, нас барсан 431, шилжин явсан 5321 хувийн хэргийг ангилан ялгаж тоолсон. Нийт **109707** хувийн хэргийн **353267** хуудас ИУБ маягтыг тоолж, **EXCEL** файл үүсгэн бүртгэсэн байна.<br>Нас барсан иргэдийн 431 хувийн хэргийг ИУБ-18 санд шилжүүлж, шилжин явсан 5321 иргэдийн хувийн хэргийг ангилан ялгаж холбогдох нэгжүүдэд хүргүүлэхэд бэлэн болоод байна.<br>Хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын тооллогыг төлөвлөгөөт хугацаандаа буюу 11 сарын 10-30-ны хооронд багтаан бүрэн тоолж дуусгалаа. Тооллогын дүнгээр Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 534657 хуудас бүхий 8611 хувийн хэрэг, газар өмчлөх эрхийн бүртгэлийн 417298 хуудас бүхий 9750 хувийн хэрэг тоологдсон байна. Хувийн хэргийн тооллогыг хийхдээ цахим сантайгаа тулган тоолсон нь илүү үр дүнтэй ажил болсон ба үүний үр дүнд газрын 161, үл хөдлөх эд хөрөнгийн 457 хувийн хэргийн зөрчил, алдааг илрүүлэв. Мөн тооллогын ажлыг хийхдээ хувийн хэрэгт цаасан баримтыг нэмэгдүүлж, хувийн хэрэг архивын хайрцагандаа | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | багтахгүй болоод байсан нөхцөл байдлыг шийдвэрлэх үүднээс цахимжуулалтын үеийн ангилан ялгалтаар хувийн хэрэг бүрт тусгаарлагдсан нотлох баримтыг салгаж 250 хуудас бүхий нэгж үүсгэн архивлах ажиллагааг хийсэн ба газар өмчлөх эрхийн бүртгэлийн 2609 хувийн хэргээс 60878 хуудас бүхий, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 3696 хувийн хэргээс 197930 хуудас бүхий нотлох баримтыг салгаж хадгаламжийн нэгж үүсгэн архивлахад бэлтгэн үдэж цэгцлэх ажил хийгдэж байна. Хуулийн этгээдийн хувийн хэргийн тоо 2387 байна. | |
| 2.4.3 | Байгууллагын ББНШАЗК-ын үйл ажиллагаанд хяналт тавих, хэлтсийн 2021 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, батлуулах, хөтлөгдөж дууссан баримт бичгийг устгах ажлыг зохион байгуулах | - | -Жагсаалтыг эцэслэн батлуулсан эсэх;<br>-Устгасан баримт бичгийн тоо; | Хэлтсийн 2020 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан 2020 оны 02 дугаар сарын 07-ний өдөр батлан мөрдөж, хадгалах хугацаа дууссанбаримт бичгийг устгах ажлыг 1 удаа зохион байгуулсан. | Жагсаалтыг үйл ажиллагаандаа мөрдсөн байна. | Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комисс нь 2021оны 1 сарын 28-нд ээлжилт хуралдаанаа хийж 2020 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг шинэчилж 2021 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг шинэчлэн батлав.<br>-Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 11/622 дугаар чиглэл, зөвлөмж хүргүүлэх тухай албан бичиг, 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 02 дугаартай Улсын бүртгэлийн хэлтсийн ББНШК-ын хурлын тэмдэглэлийн дагуу тус хэлтсийн бүртгэлийн үйл ажиллагааны явцад үүссэн баримт бичгийн хадгалах | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацаа нь дууссан, мэдээлэл лавлагаанд ашиглагдахгүй, архивын санд хадгалах шаардлагагүй устгах баримтын жагсаалтын дагуу нийт 1077 хадгаламжийн нэгж 31845 хуудас бүхий устгах баримт бичгийг 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 15 цаг 00 минутанд архиваас гарган холбогдох журмын дагуу устгав. | |
| **ГУРАВДУГААР ЗОРИЛГО: ХУУЛИАР ОЛГОСОН ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | | | | | |
| 3.1.1 | Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар УБЕГ-аас гаргасан нарийвчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах, дэд төлөвлөгөө батлах | - | -Нарийвчилсан төлөвлөгөөний биелэлтийн хувь;<br>-Дэд төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь; | - | Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө болон дэд төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлсэн байна. | Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар Хэлтсийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэд төлөвлөгөөг 01 дүгээр сарын 29-ний өдөр 5 чиглэлээр 24 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллан илтгэх хуудыг хугацаанд нь хүргүүлсэн. | 100 хувь |
| 3.1.2. | Хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдэд улсын бүртгэлийн мэдээ тайлан, мэдээлэл хүргүүлэх | - | -Хууль тогтоомжийн дагуу мэдээ, тайланг үнэн, зөв гаргасан байх;<br>-Мэдээ, тайланг хугацааны хувьд хоцрогдолгүй хүргүүлэх; | Хуулиар тогтоосон шаардлага хангасан этгээдийг мэдээ, мэдээллээр бүрэн хангаж ажилласан. | Холбогдох мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байна. | УБЕГ-т 2021/01/15-ны өдөр 100-аас дээш настны судалгааг, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд Баянхонгор аймгийн сонгуулийн насны иргэдийн тоон мэдээллийг, хэлтсийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ тайланг 11 удаа тус тус үнэн зөв гаргаж хүргүүлэн ажиллалаа. | 100 хувь |
| **ДӨРӨВДҮГЭЭР ЗОРИЛГО: ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | | | | | |
| **Зорилт 5.** Улсын бүртгэлийн байгууллагын удирдлагын менежмент, хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, мэргэжлийн боловсон хүчний чадавхыг дээшлүүлнэ. | | | | | | | |
| 4.5.1 | Хэлтсийн даргын Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай | - | -Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Улсын | 2020 онд гүйцэтгэлийн төлөвлөгөө 90 хувьтай хэрэгжсэн. | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн | Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах | | бүртгэлийн ерөнхий газрын даргаар хянуулсан эсэх; -Гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд холбогдох газруудад хүргүүлсэн эсэх; | | хангаг ажилласан байна. | цахимаар 2020 оны 11 сарын 29-ний өдөр хүлээн авч түүнд нийцүүлэн хэлтсийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулан 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдөр, Бодлого төлөвлөлт дүн шинжилгээний газраас 2021 оны 02 дугар сарын 4-ний өдөр ирүүлсэн зөвлөмжийн дагуу засвар өөрчлөлтийг оруулан 2021 оны 2 дугаар сарын 15-ны өдөр дахин боловсруулж u.munkhtsetseg@burtgel.gov.mnх аягаар, эцсийн байдлаар эх хувиар 2 хувь хэвлэн 2 сарын 17-нд тус тус УБЕГ-т хүргүүлж батлуулж хэрэгжилтийг хангаг ажиллаж байна. Эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг хугацаанд цаасаар болон цахимаар хүргүүлэн, гүйцэтгэлийн хувь 73,1 хувьтай дүгнэгдсэн. Цаашид хэрэгжилтэд анхаарах зөвлөмжийн дагуу төлөвлөгөөний биелэлтийг эрчимжүүлэн 10-11 саруудад архивын тооллого, хөдөө сумдад ажиллах ажлуудыг шуурхай зохион байгуулж маш их ачаалалтай ажиллалаа. . | |
| 4.5.2 | “Хэлтсийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөө 2021”–ыг боловсруулж, хэрэгжилтийг хангаг ажиллах | - | -Сургалтын төлөвлөгөө батлагдсан эсэх; -Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь; | 2020 онд 20 заалт бүхий сургалтын төлөвлөгөө боловсруулж батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувийн биелэлттэй гарсан. | Төлөвлөгөөний дагуу сургалтууд зохион байгуулагдаж, хэрэгжилт бүрэн хангагдсан байна. | Хэлтсийн албан хаагчдаас 2021 оны сургалтын төлөвлөгөөнд санал авч нэгтгэн баталсан боловч корона вирусын тархалтаас шалтгаалсан хөл хориотой холбоотойгоор хэлтсийн сургалт мэдээллийн | 100 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цагийг 2021 оны 02 дугаар сарыг дуустал хугацаанд хийж, түүнээс хойш цаг үеийн тулгамдсан асуудлаар хамт олны сургалт мэдээллийн цагийг хэлтсийн хаалттай группээр, онлайнаар 5 удаа, сумдын бүртгэгчдэд өгөх сургалтыг онлайнаар 8 удаа зохион байгуулан ажилласан. 2021 онд нийт 18 заалт бүхий сургалтын төлөвлөгөө боловсруулж батлан, төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн ханган ажиллалаа. | |
| 4.5.3 | Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр зохион байгуулагдсан сургалт, заавартай холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах | - | -Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо;<br>-Заавартай танилцсан албан хаагчийн тоо; | - | Албан хаагчдыг бүрэн хамруулсан байна. | УБЕГ-аас зохион байгуулсан онлайн 18 сургалтанд холбогдох албан хаагчдыг бүрэн, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 27 удаагийн сургалтанд мөн хэлтсийн албан хаагчдыг 50 хувь онлайнаар хамруулан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн холбогдох хэсгийн хэрэгжилтэд тооцон ажиллаж байна. Мөн 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдөр танхимын бүсчилсэн сургалтыг зохион байгуулж хэлтсийн албан хаагчид бүрэн, төвд танхимаар зохион байгуулсан 3 сургалтанд хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагчид тус тус хамрагдсан болно.УБЕГ-аас өгсөн ХННС-ийн сургалтанд холбогдох албан хаагчид бүрэн хамрагдаж нийт албан хаагчид | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өөрсдийн мэдээллийг бүрэн шивж оруулсан болно. | |
| **Зорилт 6.** Улсын бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| 4.6.1 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хяналт тавих | - | -Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь;<br>-Мэдээ тайланг үнэн зөв гаргасан байдал; | 2020 онд тус хэлтэст нийт 214 өргөдөл гомдол ирснийг шийдвэрлэж хариуг өгсөн. Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 2. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 99,06 хувьтай байна. | Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, тайланг УБЕГ, аймгийн ЗДТГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна. | Тайлант хугацаанд хэлтсийн хэмжээнд нийт 188 өргөдөл, гомдол, хүсэлт ирсэн байх ба үүнээс шийдвэрлэгдсэн 166, хугацаа болоогүй 22, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй байна. Мөн ирсэн өргөдөл, гомдлыг Able программ дээр болон өргөдөл, гомдлын дэвтэр дээр бүртгэн хяналтын картыг хөтлөж байна. | 100 хувь |
| 4.6.3 | Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн эргэлтэд хяналт тавих | - | -Баримт бичгийн эргэлтийн тоо;<br>-Хугацаатай хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн хувь; | 2020 оны жилийн эцсийн байдлаар тус хэлтэст нийт 895 бичиг ирсэн, үүнээс хариутай албан бичиг 665 байсан. Хариутай албан бичгийг шийдвэрлэлтийн байдал 100 хувьтай. | Хэлтсийн албан хэрэг хөтлөлт стандартын дагуу явагдсан байна. | Хэлтсийн хэмжээнд 2021 оны 12 дугаар сарын 03-ны байдлаар ирсэн албан бичиг 836, Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын даргын тушаал, чиглэл, зөвлөмж , дотоод албан бичиг нийт 59 тус тус бүртгэгдсэн байх ба хэлтсээс 927 албан бичиг явуулсан байна.<br>Ирсэн, явсан албан бичиг болон өргөдөл, гомдлыг скайнердэж **Able** программ дээр бүртгэн хяналтын карт хөтлөн хяналт тавин ажиллаж байна.<br>Хэлтэст нийт 601 **хариутай албан бичиг ирүүлсэн ба** хуулийн хугацаа хэтрүүлэн хариу илгээсэн албан бичиг байхгүй болно. | 100 хувь |
| 4.6.4 | Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний | - | -Үйлчилгээний стандартын хэрэгжилтийн хувь; | - | Үйл ажиллагаандаа дүрэм, журмыг мөрдөж, стандартын зөрчил гараагүй | Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих | | -Ёс зүйн арга хэмжээ авагдсан албан хаагчдын тоо; | | байна. | чанд мөрдөн ажиллаж байна. Зөрчсөн талаар ямар нэгэн санал гомдол ирээгүй, хэрэгжилтэд байнгын хяналт тавин ажиллаж байна. Аймгийн ТАСЗ-өөс зохион байгуулсан "Ес зүй -хандлага зөвтэй" төрийн алба сарын аянд нэгдэж хэлтсийн дарга, нягтлан бодогч, хяналтын улсын байцаагч нар 10 сарын 11-ээс 11 сарын 11-ний хооронд Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд өдөр тутмын хяналт тавин ажиллав. | |
| 4.6.5 | Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд сайн дурын үндсэн дээр хамруулах ажлыг зохион байгуулах | - | Албан хаагчдыг сайн дурын үндсэн дээр эрүүл мэндийн үзлэгт хамруулсан эсэх; | -2020 онд хамруулаагүй. | Хэрэгжилт бүрэн хангагдсан байна. | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүсэлт тавьсан болно. Харин албан хаагчид зайлшгүй 3 дугаар шатлалын эмнэлэгт үзүүлж үзлэг, оношилогоо эмчилгээ хийлгэхэд зориулан 10 ажилтанд цалинтай чөлөөг олгосон болно. Албан хаагчид ковид 19 урьдчилан сэргийлэх вакцины 3 дахь тунд 87,5 хувь хамрагдсан. | 80 хувь |
| 4.6.6 | Даргын зөвлөлийн болон бүх албан хаагчдын хурлын тэмдэглэл хөтөлж, гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих | - | -Хөтөлсөн хурлын тэмдэглэлийн тоо;<br>-Үүрэг даалгаврын тоо;<br>-Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь; | 2020 онд 1 удаагийн даргын зөвлөлийн шуурхай хуралдаан зохион байгуулж, албажуулсан ба нэгжүүдэд 3 үүрэг даалгавар өгөгдсөний хэрэгжилт 100 хувийн биелэлттэй. | Тэмдэглэлийг тухай бүр нь албажуулан хурлаас өгөгдсөн үүрэг, даалгавруууд бүрэн хэрэгжсэн байна. | Хурлын зохион байгуулалтын ажлыг тухай бүр хийж гүйцэтгэсэн бөгөөд тайлант хугацаанд даргын зөвлөлийн 1 удаагийн хурлаар бүртгэлийн алдаа зөрчил гаргахгүй байх анхааруулга санамжийг өгөв.<br>Хамт олны хурлыг 4 удаа , цахимаар 2 удаа хийсэн болно. | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.6.7 | Улсын бүртгэлийн ерөнхий газраас байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн даргын тушаал шийдвэрийг хяналтад авч бүртгэл хөтлөх | - | Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой даргын тушаал, шийдвэрийн тоо, хяналтад авсан эсэх; | 2020 оны жилийн эцэст тус хэлтэст УБЕГ-ын даргын тушаал, чиглэл зөвлөмж, дотоод албан бичиг нийт 102 ирсэн. | Тушаал шийдвэрийн бүртгэлийг сар, өдрийн дараалаар нарийн хөтөлсөн байна. Хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна. | ***2021 онд нийт хэлтсийн даргын 17*** тушаал гарч хэрэгжсэн. УБЕГ-аас ирүүлсэн чиглэл, үүрэг даалгаврыг ирсэн он дараалын дагуу бүртгэлийг нарийн хөтөлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. нийт 59 шийдвэр байна. | 100 хувь |
| 4.6.8 | Байгууллагын нууцын ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах | - | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил зохион байгуулагдаж, шаардлагатай арга хэмжээ авч ажилласан эсэх; | 2020 онд Төрийн болон албаны нууцтай холбоотой хариутай албан бичиг ирээгүй. Нууцын тайланг аймгийн Тагнуулын хэлтэс, УБЕГ-т хугацаанд нь тус тус хүргүүлсэн. | Хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна. | 2021 оны гарсаар хэлтсийн нийт албан хаагчдаас гүйцэтгэж буй ажил үйлчилгээтэй холбоотойгоор нууцын баталгааг гаргуулан авсан, мөн МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд заасны дагуу Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнаар томилогдон ажиллаж буй нийт 102 албан хаагчаас нууцын баталгааг гаргуулан авч , хяналт тавьж ажиллалаа. Аймаг дахь Тагнуулын хэлтэст 2020 оны нууцын ажлын тайланг хугацаанд нь гарган хүргүүлсэн. Итгэмжлэгдсэн ажилтнуудын онлайн сургалтыг 5 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулж хөтөлбөрийн дагуу мөн Тагнуулын хэлтсийн ажилтан Батхүлэгээр “Төрийн болон албаны нууцын тухай “ болон Мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан. . 2021 оны шинээр томилогдсон 2 албан хаагчаас нууцын баталгааг гаргуулан авч хууль тогтоомжийг тайлбарлан | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | таниулж унших судлах үүргийг өгсөн болно. Тагнуулын хэлтсээс ирүүлсэн албан бичгийн дагуу эрсдлийн судалгааг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. | |
| 4.6.9 | Байгууллагаас сар бүр үзүүлсэн үйлчилгээний талаар инфографик мэдээлэл бэлтгэх, олон нийтэд хүргэх | - | Сар бүр иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний талаарх инфографик мэдээллийг бэлтгэн брошур хэлбэрээр байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан тоо; | 2020 онд фэйсбүүк хуудас болон цахим хуудсанд 12 удаа байршуулсан.Мөн байгууллагын мэдээллийн самбарт 12 удаа байршуулсан. | Сар бүр мэдээлэл байршуулсан байна. | Улсын бүртгэлийн сар бүрийн тоог мэдээг тухай бүр нь үнэн зөв гаргаж тус тус хугацаанд нь хүргүүлсэн. Мөн Хэлтсийн bayankhongor.burtgel.gov.mn хаягийн сар бүрийн тоо мэдээ цэст 12 удаа байршуулсан болно. | 100 хувь |
| 4.6.10 | Хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох | - | -Хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон тоо;<br>-Шийдвэрийн мэдээлэл;<br>-Хэрэг маргааны судалгаа эрх зүйн хэлтэст хүргүүлсэн байдал; | 2020 онд тус хэлтэстэй холбоотой хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаан байхгүй. | Хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, байгууллагын эрх ашгийг бүрэн хамгаалсан байна. | 2021 оны 12 дугаар сарын 02-ны байдлаар тус хэлтэстэй холбоотой хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаан байхгүй. | |
| 4.6.11 | Байгууллагын үйл ажиллагааг цахим, фэйсбүүк хуудсаар болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр | - | -Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой | 2020 онд хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлийг цахим болон фэйсбүүк хуудсанд 83 | Байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон цаг үеийн чанартай хийж хэрэгжүүлж буй ажлын талаар иргэд, | 2021 оны хэлтсийн үйл ажиллагааны талаар [https://bayankhongor.burtgel.gov.mn/](https://bayankhongor.burtgel.gov.mn/) сайт болон байгууллагын facebook page хуудсуудаар | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сурталчлах, телевиз радиогийн нэвтрүүлэгт оролцох | | мэдээ, мэдээллийг цахим хуудаст байршуулсан тоо;<br>-Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслэээр сурталчилсан тоо; | удаа байршуулсан.<br><br>Орон нутгийн телевиз, сонинд 3 удаа мэдээлэл хийсэн. | олон нийт мэдээ мэдээлэлтэй болсон байна. | дамжуулан иргэдэд түгээж байна. Мөн бүртгэлүүдийн талаар шинэ гарын авлага, болон шинэ мэдээ мэдээллийг байршуулан ажиллаж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар [https://bayankhongor.burtgel.gov.mn/](https://bayankhongor.burtgel.gov.mn/) сайтад 33 удаагийн мэдээ мэдээлэл, Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс facebook page хуудсанд 217 удаагийн мэдээлэл тавьж ажилласан байна. Мөн шинэ төрлийн корона вирусаас урьдчилан сэргийлэх болон цахимаар авч болох үйлчилгээний талаарх мэдээ мэдээллийг зурагт хуудсаар бэлтгэн олон нийтийн сүлжээгээр түгээн ажиллаж байна.<br>УБЕГ болон хэлтсийн facebook page хуудаст байршуулан мэдээ мэдээллийг нийт 40 албан хаагчдыг тухай бүр нь лайк, шэйр хийж байхыг үүрэг болгон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | |
| 4.6.12 | Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулах | - | “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулсан тоо; | 2020 онд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 1 удаа зохион байгуулсан. | Нээлттэй хаалганы өдөрлөгийг 2-с доошгүй удаа зохион байгуулсан байна. | Төлөвлөгөөний дагуу 11 дүгээр сарын 9-13-ны өдрүүдэд Баянговь , Баянцагаан сумдад, 12-ны өдөр хэлтсийн байранд тус тус нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж явуулав. Тус өдөр бүртгэлийн байгууллагын үзүүлэх | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургуулилтыг үзэж сонирхох, зөвлөгөө мэдээлэл авах, бүртгэлийн үйлчилгээ авахаар нийт 218 иргэн хүрэлцэн ирснээс бүртгэлийн үйлчилгээг 115 иргэнд, хэлтсийн цахим үйлчилгээний булангаар Е - mongolia протайл сайтаас 18 иргэнд лавлагаа хэвлэн өгөх, татварын нэхэмжлэхийн дугаарыг олгох үйлчилгээг 38 иргэнд тус тус үзүүллээ. Мөн орон нутгийн телевизтэй хамтран ажиллаж "Нээлттэй хаалганы өдөр-Үзүүлэх сургуулилт"-ын бичлэгийг нэвтрүүлгээр бэлтгэн олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулан ажиллалаа. | |
| 4.6.13. | Иргэдийн санал хүсэлтийг сонсох 70442177 утасны үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах | - | -Утсаар лавлагаа мэдээлэл авсан тоо; | Хэлтсийн лавлах утсанд 1295 иргэн утсаар холбогдсон, тухай бүр шийдвэрлэсэн. | Улсын бүртгэлийн чиглэлээр иргэдэд үнэн зөв, бодитой мэдээлэл хүргэсэн байна. | Хэлтсийн үйлчилгээний заал болон хэлтсийн даргын өрөөний суурин утсуудаар нийт 9000 гаруй удаа мэдээлэл өгч ажилласан ба өндөржүүлсэн бэлэн байдлын үед өгч эхэлсэн өдөр тутмын мэдээнд мэдээлэгдсэн болно. | 100 хувь. |
| 4.6.14. | Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шинэчлэн боловсруулах шаардлагатай дүрэм, журмын төсөлд санал хүргүүлэх | - | -Шинэчлэн боловсруулсан дүрэм, журмын төслийг хүлээн авсан байх<br>-Эрх зүйн актын төсөлд санал хүргүүлсэн эсэх | Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдах 6 журам, 4 загварын төсөлд санал хүргүүлсэн. | Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай дүрэм, журмын төсөлд санал хүргүүлсэн байна. | -2021/01/18-ны өдөр Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд санал, 2021/01/28-ны өдөр Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын төсөлд саналаа тус тус хүргүүлэн ажиллалаа.<br>-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн төсөлд нэмэлт, | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өөрчлөлт оруулахтай холбоотойгоор 6 саналыг edkhurungu@burtgel.gov.mnхаяг аар 2020 оны 12 сарын 28-нд хүргүүлсэн байна. “Эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагааны заавар”-т холбогдох 12 саналыг edkhurungu@burtgel.gov.mn хаягаар хүргүүлсэн байна. | |
| **Зорилт 7.** Гадаад хамтын ажиллагаа өргөжүүлж, улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын бүртгэлийн байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллана. | | | | | | | |
| 4.7.1 | Аймгийн ИТХ, Засаг дарга болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж дэмжлэг авах | Орон нутгийн төсөв | Санал тавьж шийдвэрлүүлсэн эсэх; | 2020 онд Иргэний улсын бүртгэлийн тасагт иж бүрэн 4 шинэ компьютер, 3 үйлдэлтэй 1 ш принтер шийдвэрлүүлсэн. | Тулгамдсан асуудлаа шийдвэрлүүлсэн байна. | Аймгийн Засаг даргад 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдөр 1/98 тоот албан бичгээр хэлтсийн албан байрны гадна тохижилтын ажилд хөрөнгө шийдвэрлүүлэх тухай, 2021 оны 2 дугаар сарын 10-ны 1/125 тоот хүсэлт хүргүүлэх тухай албан тоотоор хэлтсээс эрх зүйч мэргэжлээр суралцаж буй албан хаагчдын сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх болон хэлтсийн албан хэрэгцээнд автомашин шийдвэрлэж өгөх хүсэлтүүдийг тус тус хүргүүлэн ажиллалаа. 2021 оны 10 сард албан тоотоор хүсэлт илгээж 5 сая төгрөгийг шийдвэрлүүлж цахим үйлчилгээний буланг шинэчлэн тохижуулж шинэ компьютер, принтер, түүнийг байрлуулах бүхээг бүхий шүүгээ, сүлжээний | 90 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | утас зэргийг худалдан авч ашиглалтанд оруулав. | |
| 4.7.2. | Орон нутгийн өөрийн удирдлагын болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж зарим сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг сумдад очиж ажиллан иргэдэд түргэн шуурхай үйлчлэх ажлыг үргэлжлүүлэх | | 2-оос доошгүй суманд очиж ажилласан байна. | 2020 оны 06 дугаар сарын 2-ноос 4-ний хооронд Богд суманд ажиллаж **120** гаруй иргэдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хууль тогтоомжийг танилцуулж биечлэн зөвлөгөө өгөхийн зэрэгцээ **102** бүртгэл хийж эрх зүйн туслалцаа үзүүлэв. Хүрээмарал суманд 10 сарын 16-ны өдөр ажиллаж Зөрчлийн тухай хууль болон услын бүртгэлийн багц хуулиудаар мэдээлэл хийж хугацаа хэтрүүлсэн 2 зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч газар дээр нь хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн байна. | 2-оос доошгүй суманд очиж ажиллан иргэн, аж ахуйн нэгжид эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ болон зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг түргэн шуурхай хүргэсэн байна. | “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг хөдөө сумдад хүргэх” зорилтын хүрээнд 2021 оны 11 сарын 09 -өөс 11 сарын 13 -ны өдрүүдэд хяналтын улсын байцаагч Л.Мэндбаяр, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Т.Мягмарсүрэн нар Баянговь, Баянцагаан сумдад ажилласан ба энэ үйл ажиллагааг сумын Нээлттэй хаалганы өдөртэй хамтатган хийсэн нь онцлогтой боллоо. Тус сумдад улсын бүртгэлийн чиглэлээр үзүүлж буй ажил, үйлчилгээг иргэдэд сурталчилж, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг 112 иргэнд үзүүлж, газар өмчлөх эрхийн болон үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг газар дээр нь олгож ажиллалаа. Мөн 68 иргэнд E-Mongolia цахим үйлчилгээний нэгдсэн системийн талаар мэдээлэл хүргэж, гарын авлага тарааж, давхардсан тоогоор 180 иргэнд бүртгэлийн үйлчилгээг үзүүллээ. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг сумдад газар дээр нь очиж шийдвэрлэсэн нийт 27 зөрчил байна. | 100 хувь |
| 4.7.3. | .”Цахим архив – Баянхонгор” дэд | - | Заасан | 2020 онд Байгууллагын архивын 2017 оны | 2018 оны байнгын | Аймгийн Төрийн архивын тасгаас ковид илэрсэн болон | 85 хувь. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах. | | хугацаанд нь хүлээлгэж өгсөн эсэх. | байнгын баримтуудыг цахим архив үүсгэн хугацаанд нь хүлээлгэж өгч ажилласан. | баримт болон тухайн оны онцлох үйл ажиллагааны тусгай төрлийн баримтыг цахим архив үүсгэн хуваарийн дагуу Аймгийн Төрийн архивын тасагт хүлээлгэж өгсөн байна. | Төрийн архивын улсын үзлэгтэй холбоотой Аймгийн Архивын тасаг нь бэлтгэл хангаж байгаа тул хугацаандаа хүлээн аваагүй. Харин өмнөх онуудад хүлээлгэж өгөөгүй байсан 2007, 2008, 2009, 2010 оны байнгын баримтуудыг нөхөн хүлээлгэж өгсөн. | |
| 4.7.4. | Байгууллагын тусгай төрлийн баримтыг Төрийн архивт шилжүүлэх | - | Баримтыг заасан хугацаанд бүрэн шилжүүлсэн эсэх | 2020 оны тусгай төрлийн баримтыг хугацаанд нь төрийн архивт хүлээлгэж өгсөн. | 2021 оны тусгай төрлийн баримтыг Төрийн архивт бүрэн шилжүүлсэн байна. | Байгууллагын тусгай төрлийн 40 ш зурган баримтыг фото студээр угаалган Төрийн архивт 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүлээлгэн өгсөн. | 100 хувь |
| 4.7.5. | Улсын бүртгэлийн хэлтсийн албан байрны гадна тохижилтын ажлыг зохион байгуулах. | Орон нутгийн төсөв | -Тохижилтын ажлыг хийх ажлын зураг, тохижилтын зургийг гарган хүргүүлсэн байх;<br>-Ажлын гүйцэтгэгчийг хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байх;<br>-Гадна тохижилт, автозогсоол, зүлэгжүүлэлт хийгдсэн байх | -2014 онд ашиглалтад орсон, гүйцэтгэгч компаниас ажлыг чанарын шаардлагын түвшинд хүлээн аваагүй орчны тоосжилт ихтэй, авто машины зогсоол бага. | Улсын бүртгэлийн хэлтсээр үйлчлүүлэгчдийн тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцөл бүрдсэн байна. | Аймгийн Засаг даргад 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдөр 1/98 тоот албан бичгээр хэлтсийн албан байрны гадна тохижилтын ажилд хөрөнгө шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг тохижилтын зургийн хамтаар хүргүүлсэн боловч цар тахлын улмаас орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудын хөрөнгө урьдчилан сэргийлэх ажилд зарцуулагдсан тул энэ жил боломжгүй тухай хариу албан тоот ирүүлсэн болно. | 80 хувь |
| **Зорилт 8.** Санхүү, төсвийн удирдлага болон төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлнэ. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.8.1 | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулах, тайлагнах, байршуулах | 518620,4 | -Төсвийн өр, авлага үүсгэсэн эсэх;<br>-Төрийн аудитын шалгалтаар зөрчилгүй ажилласан эсэх; | 2020 онд зөрчилгүй дүгнэлт авсан. | Байгууллагын төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулж, тайлан мэдээг холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлж, аудитын зөрчилгүй дүгнэлт авсан байна. | 2021 оны 11 дүгээр сарын 29-ний байдлаар улсын төсвөөс 546.061.3 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч цалин хөлсний зардалд 411.966.5, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 64.488.1, гэрэл цахилгааны зардалд 2.109.9, түлш халаалтын зардалд 38.301.2,цэвэр бохир усны зардалд 1.270.4, бичиг хэргийн зардалд 4.848.9, тээвэр шатахууны зардалд 4.299.0, шуудан холбооны зардалд 1.582.6, хог хаягдал зайлуулах зардалд 550.0, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардалд 1.164.5, багаж техник хэрэгслийн зардалд 166.0, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардалд 96.8, урсгал засварын зардалд 60.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 344.1, тээврийн хэрэгслийн татварын зардалд 120.0, тээврийн хэрэгслийн оношлогооны зардалд 22.0, бараа үйлчилгээний бусад зардал 344.1, /2021 оны Монгол Улын Ерөнхийлөгчийн сонгууль/-д 91.218.9, хичээл үйлдвэрлэлийн зардалд 488.0 мянган төгрөг зарцуулж улсын төсвийн орлогын дансанд үндсэн үйл ажиллагааны орлого 207.044.5, орон нутгийн төвлөрүүлэх орлогот /тэмдэгтийн хураамж / 14.240.4 мянган төгрөг | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төвлөрүүлэн ажиллалаа.<br>Төрийн Аудитын байгууллагаас “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан болно. | |
| 4.8.2 | Улсын бүртгэлийн байгууллагын байрны ашиглалт, үнэт цаас, маягт, бараа материалын хангалт, үйлчилгээг хариуцан зохион байгуулах зарцуулах, тайлагнах | - | -Төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг цаг тухайд хийсэн болон ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн эсэх;<br>-Үнэт цаас, маягт болон бусад бараа материал, жижиг эд хогшлын хангалтыг тасалдуулаагүй эсэх;<br>-Байгууллагын үнэт цаас, маягт болон бусад бараа материалыг хэмнэлттэй зарцуулсан болон батлагдсан төсөв хэмнэсэн эсэх; | 2020 онд эд хөрөнгийн тооллогыг хийсэн, байрны ашиглалт, үйлчилгээг хэвийн, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан. | Хагас жилээр эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийсэн, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн өмнө байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийсэн, ашиглалтгүй хөрөнгийг данснаас хасах талаар байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр гаргуулж, УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлсэн байна. | УБЕГ-ын Санхүү, аж ахуй хэлтсээс 26.951.7 мянган төгрөгийн үнэт цаас, бараа материал, covid -19 цар тахалтай холбоотойгоор нэг удаагийн хамгаалах хэрэгсэл 31.972.0 төгрөгийн материалыг хүлээн авч 33.434.4 мянган төгрөгийн үнэт цаас, бусад хангамжийн материалыг хөрөнгийн бүртгэлд хөдлөл өөрчлөлтөөр бүртгэн сар бүр үнэт цаасны тайлан няравын тайланг гаргуулан авч, хүргүүлсэн.<br>Улсын бүртгэлийн зарим үйлчилгээ цахимжсанаар цаашид ашиглахгүй болсон 1702,500 төгрөгийн үнэт цаасыг УБЕГ-т шилжүүлж хөдлөл өөрчлөлтийг бүртгэсэн. Жилийн эцсийн тооллогын бэлтгэл ажлын хүрээнд элэгдлээ нөхсөн, ашиглах хугацаа дууссан хөрөнгийн жагсаалтыг гаргаж өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэх үүргийг өгсөн болно. | 100 хувь |
| 4.8.3 | Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах | - | -Байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо;<br>-Хугацаандаа байршуулсан эсэх; | 2020 оны 12 сарын 25-ны байдлаар шилэн дансны цахим сайтад 149 мэдээлэл оруулахаас 149 хугацаа хоцролгүй, үнэн зөв | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна. | Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын тогтоолын дагуу байгууллагын санхүүгийн мэдээллийг www.shilendans.gov.mn, сайтад сар бүр тогтмол байршуулан | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байршуулсан. Шилэн дансны мэдээлэл байршуулалт сайн авбал зохих 2 оноогоо авсан | | 122 удаагийн мэдээлэл шинэчилж, www.bayankhongorburtgel.com сайтад тогтмол байршуулан 10 удаагийн мэдээлэл шинэчилж ажилласан. | |
| 4.8.4 | Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулж, тогтмолжуулах | - | -Төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах;<br>-Хүчингүй болсон үнэт цаас, тамга тэмдгийг журмын дагуу устгах;<br>-Төрийн болон орон нутгийн өмчийн улсын тооллогод бэлтгэх;<br>- Байгууллагын эд хөрөнгийн тооллого хийх;<br>-Байгууллагын эд хөрөнгийн бүртгэлийн сантай болох;<br>-Хэрэглэгдэж байгаа бүх тоног төхөөрөмжийн ашиглалт үзүүлэлтийн судалгаа гаргах;<br>-Тайланг 2 удаа хагас бүтэн жилээр гаргаж тайлагнах; | Байгууллагын эд хөрөнгийн тооллого, хүчингүй болсон үнэт цаасны зарцуулалт, ашиглалтын хугацаа дууссан эд хөрөнгийг актлах зэргээр 3 удаа санал хүргүүлсэн. | Өмч хамгаалах зөвлөлийн ажил тогтмолжсон байна. | Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулж зөвлөлийн ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаң ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлт, ажлын тайланг 25-ны өдрөөр эцэслэн гаргаж хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллаж байна.<br>Бүртгэлийн явцад улсын бүртгэгчийн болон техникийн алдаанаас хүчингүй болгосон 369 ширхэг үнэт цаас маягтыг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн устгах комисс томилон устгасан.<br>Жилийн эцсийн тооллогын бэлтгэл ажлын хүрээнд элэгдлээ нөхсөн, ашиглах хугацаа дууссан хөрөнгийн жагсаалтыг гаргаж өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэх үүргийг өгсөн болно.<br>Байгууллагын эд хөрөнгийн бүртгэлийн сангийн баяжилтыг тухай бүр нь хийж хэвшсэн.<br>Архивын улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд тоног төхөөрөмжийг ашиглалт үзүүлэлтийн судалгааг шинэчлэн гаргасан. | 90 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.8.5. | Байгууллагын хэвийн үйл ажиллагааг болон дараа жилийн зорилтыг хангахуйц төсвийг төлөвлөх, хүргүүлэх, батлуулах | | Санхүүгийн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах нөхцлөөр бүрэн хангахуйц 2022 оны урсгал зардлын төсвийн төслийг боловсруулж хүргүүлсэн эсэх | 2021 төсвийн төслийг хугацаанд хүргүүлсэн. | 2022 онд байгууллагын төсөв, байгууллагын үйл ажиллагааг хэвийн, найдвартай, тасралтгүй явуулахад хүрэлцэхүйц төсөвлөсөн төслийн саналыг хүргүүлсэн байна. | Байгууллагын 2022 оны төсөв, 2022-2023 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд гарган УБЕГ-т хэлтсийн даргын 07 дугаар сарын 08-ны өдрийн 2/520 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 100 хувь |

---------oOo----------